



**МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

Засгийн газрын XI байр, Самбуулийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15141
Утас: 26 42 16, Факс: (976-51) 26 44 60,
Цахим шуудан: info@csc.gov.mn,
Цахим хуудас: www.csc.gov.mn

2025.01.08 № 05/39

танай _____ -ны № _____ -т

УЛСЫН ИХ ХУРЛААС УДИРДЛАГА,
БҮРЭЛДЭХҮҮН НЬ ТОМИЛОГДДОГ
БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН АЛБАНЫ
БОЛОН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
НАРТ, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДЭД ДАРГА
Б.БАТЦЭЦЭГ, ТӨРИЙН АЛБАНЫ
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА НАРТ

Хамтран ажиллах тухай

Төрийн албаны зөвлөлөөс баталсан "Төрийн албаны реформ-бидний шийдэл" сэдвээр зохион байгуулах эрдэм шинжилгээний бүтээл шалгаруулах удирдамжийг хавсралтаар хүргүүлж байна.

Төрийн албан хаагчийн санаачилга, шинэлэг шийдэл бүхий судалгаа, практик ач холбогдолтой санааг төрийн албаны шинэчлэлд тусгах зорилгоор энэхүү үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөөд байгаа болно.

Иймд удирдамжийн дагуу бүтээл ирүүлэхэд харьяалах салбар, байгууллагуудын төрийн албан хаагчдад дэмжлэг үзүүлж, мэдээлэл түгээн хамтран ажиллахыг хүсье.

Хавсралт 3 хуудастай.

ГИШҮҮН



ЦАМАРТӨГС

15 5070091



БАТЛАВ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА
Л. ЦЭДЭВСҮРЭН

**"ТӨРИЙН АЛБАНЫ РЕФОРМ-БИДНИЙ ШИЙДЭЛ"
ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
БҮТЭЭЛ ШАЛГАРУУЛАХ УДИРДАМЖ**

2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Зорилго

"Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогын 5.4 дэх зорилт, Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.3.7 дахь зорилтын хэрэгжилтийг хангах хүрээнд судалгаанд суурилсан төрийн албаны шинэтгэлийг бэхжүүлэх, төрийн албан хаагчдын судалгаа шинжилгээний чадавхыг сайжруулж, идэвхжүүлэх зорилгоор бүтээл шалгаруулж, түгээн сурталчилна.

Хоёр. Бүтээлийн сэдэв, чиглэл

Монгол Улсын төрийн албаны реформыг чанаржуулах, хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, төрийн албаны хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх, хариуцлагдажүүлэх, инновац, технологийн шийдлийг төрийн албанд нэвтрүүлэхэд чиглэсэн "Төрийн албаны реформ-бидний шийдэл" сэдвээр нийтлэг өргөн агуулгыг хамарсан байна.

Бүтээл нь аль нэг салбарын болон нарийн мэргэжлийн асуудал хамрахгүй болно.

Гурав. Зохион байгуулалт

Бүтээл шалгаруулалт 3 үе шаттай зохион байгуулагдана.

Нэгдүгээр үе шат:

1.Төрийн албан хаагчдын судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлийг 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 09.00 цагт багтаан research@csc.gov.mn цахим хаягаар Төрийн албаны зөвлөл хүлээн авна.

2.Төрийн албан хаагчдын ирүүлсэн судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлээс 20-ийг 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 17.00 цагт багтаан шүүгчид сонгон шалгаруулж, оролцогчид мэдэгдэнэ.

3.Нэгдүгээр шатанд бүтээл нь шалгарсан төрийн албан хаагчдад судалгааны арга зүй, илтгэх ур чадварын талаарх ерөнхий заавар, зөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 24-28-ны өдрийн хооронд Төрийн албаны зөвлөлөөс цахимаар өгнө.

4.Бүтээл нь шалгарсан төрийн албан хаагч өөрийн бүтээлийн талаар дүрс бичлэг хийж 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 09.00 цагт багтаан research@csc.gov.mn цахим хаягаар Төрийн албаны зөвлөлд ирүүлнэ.

5.Төрийн албан хаагчийн дүрс бичлэг хийх үйл ажиллагаанд ажиллаж байгаа болон холбогдох төрийн байгууллага дэмжлэг үзүүлэн хамтарч бэлтгэнэ.

6.Дүрс бичлэг хийж ирүүлсэн бүтээлийг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудаст 2025 оны 3 дугаар сарын 14-28-ны өдрийн 17.00 цаг хүртэл байршуулж, төрийн албан хаагчдаас нээлттэй санал авна.

Хоёрдугаар үе шат:

1.Цахимаар авсан санал, шүүгчдийн үнэлгээнд үндэслэн шилдэг 10 судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлийг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөрт багтаан шалгаруулж, оролцогчид мэдэгдэнэ.

2.Шилдэг 10 судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл ирүүлсэн төрийн албан хаагчдад зориулан илтгэх ур чадварын хүрээнд зөвлөн туслах үйл ажиллагааг Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулна.

Гуравдугаар үе шат:

1."Төрийн албаны реформ-бидний шийдэл" сэдэвт төрийн албан хаагчдын судалгаа, эрдэм шинжилгээний шилдэг 10 бүтээлийг эрэмбэлэн шалгаруулах үйл ажиллагааг 2025 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулна.

2.Шүүгчдийн баг бүтээлийг эрэмбэлэн шалгаруулж, Төрийн албаны зөвлөлийн удирдлагын багт танилцуулна.

3.Шалгарсан төрийн албан хаагчдад мөнгөн шагнал, цом-өргөмжлөл гардуулна.

Дөрөв. Үр дүн

4.1.Иргэн төвтэй, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бий болгоход чиглэсэн бүтээл шалгаруулах зорилгыг хангахуйц шинэ мэдлэг, шинэ санааг дэвшүүлэх төрийн албан хаагчдыг идэвхжүүлэх, тэдний оролцоог хангах, мэдлэг, ур чадвар, санаачилгыг дэмжинэ.

4.2.Төрийн албан хаагчдын судалгаа шинжилгээ хийх, илтгэх ур чадварыг дээшлүүлж, мэргэшүүлэх, шилдэг судалгааны бүтээлийг туршлага болгон нэвтрүүлнэ.

4.3.Шилдэг судалгааны бүтээлүүдийн хураангуйг эмхэтгэн хэвлүүлж, түгээн дэлгэрүүлнэ.

Тав. Судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлд тавигдах шаардлага

5.1.Судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлийн бүтэц:

1	Сэдэв	Судалгааны сэдэв, гарчгийг том үсгээр бичсэн байна. Гарчиг нь бүтээлийн гол санааг агуулсан товч, тодорхой, оновчтой томъёологдсон байна.
2	Зохиогчийн мэдээлэл	Зохиогчийн овог, нэр, эрхэлдэг ажил, албан тушаал, цол зэргийг бичнэ. (Мөн хэвлэлийн шаардлага хангахуйц чанартай зураг хавсаргана.)
3	Хураангуй/ Абстракт	Хураангуй нь судалгааны ажлын агуулгын гол утга санааг товч тодорхой, ойлгомжтой байдлаар илэрхийлсэн байвал зохино.
4	Удиртгал	Судалгааны арга, зорилго, зорилт, хэрэгцээ шаардлага, дэвшүүлж буй асуудал, таамаглал, түүнийг батлахын тулд ямар сорил, туршилтыг ямар аргаар хэрхэн гүйцэтгэсэн, хэчнээн хэмжээний материал, мэдээлэл хуримтлуулж, ямар аргаар боловсруулалт хийсэн зэргээс дурдана.
5	Үндсэн хэсэг	Өөрийн судалгааны үр дүнг бусад судалгааны үр дүн, онол, аргазүйн чиглэл, үзэл баримтлалтай хэрхэн холбогдох хийгээд өөрийн таамаглалаа хэрхэн баталсан, эсвэл үгүйсгэсэн, ямар дүгнэлтэд хүрч байгаа зэргийг эшлэл, баримт, нотолгоотой гаргана. Тоон үзүүлэлтэд математик боловсруулалт хийнэ.

6	Судалгааны үр дүн	Энэ хэсэгт судлаач өөрийн гаргасан үр дүнг нотолгоотой, логик, дэс дараалалтай, эмх цэгцтэй, ойлгомжтой бичнэ
7	Дүгнэлт	Судалгааны үр дүнд гаргасан дүгнэлтээ логик дэс дараатай, оновчтой, тодорхой бичнэ
8	Эш татсан бүтээл, ашигласан материал	Судалгаанд эш татсан, ашигласан материал, бүтээлийг оруулна.

5.2. Бүтээлд тавих шаардлага:

- | | | |
|---|------------------------------------|---|
| А | Бүтээлийн техникийн шаардлага | Бүтээл 15-20 хуудастай байх,
Фонт - Arial,
Үсгийн хэмжээ - 12,
Мөр хоорондын зай - "1,15",
Цаасны формат - А4 (210 x 297mm),
Ашигтай талбайн хэмжээ дээрээс- 2 см, доороос - 2 см, зүүнээс - 3 см, баруунаас - 1.5 см хэмжээтэй байна. |
| Б | Дүрс бичлэгийн техникийн шаардлага | - Сайн камер, микрофонтой тоног төхөөрөмж ашиглаж дүрс бичлэг хийх,
- 10 минутаас хэтрэхгүй байх. |
| В | Бүтээлд тавих шаардлага | - Судалгаа, шинжлэх ухааны арга зүйг оновчтой ашигласан байх,
- Агуулга нь сэдэвтэйгээ уялдсан байх;
- Зохиогчийн эрхийг зөрчөөгүй, аливаа бүтээлийг хуулбарлаагүй байх;
- Төрийн албаны онол, практикийн тулгамдсан асуудлыг хөндсөн байх,
- Тулгамдсан асуудлыг дэвшүүлсэн эсвэл шинэ санаа, туршилт судалгааг нэвтрүүлсэн байх;
- Дүн шинжилгээ хийж тодорхой дүгнэлт гаргасан байх;
- Судалгаа, эрдэм шинжилгээний хэл найруулгын зохих шаардлагыг хангасан байх;
- Эшлэл зүүлт хийсэн байх; |

Зургаа. Шилдэг судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл ирүүлж, оролцсон төрийн албан хаагчдад олгох шагнал, урамшуулал

Гуравдугаар шатанд шалгарсан шилдэг судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл туурвисан төрийн албан хаагчдыг дараах мөнгөн шагнал, цом-өргөмжлөлөөр шагнана.

1. Нэгдүгээр байр - 1 бүтээлд мөнгөн шагнал, цом-өргөмжлөл
2. Хоёрдугаар байр - 1 бүтээлд мөнгөн шагнал, цом-өргөмжлөл
3. Гуравдугаар байр - 2 бүтээлд мөнгөн шагнал, цом-өргөмжлөл

Бүтээл туурвисан төрийн албан хаагчдад дурсгалын зүйл гардуулна.

—oOo—